

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ  
ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БОЛОН БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ ЭРХИЙГ  
ХАМГААЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 87 ДУГААР  
КОНВЕНЦ

1948 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталж, 1950 оны 7 дугаар сарын 4-ний өдөр хүчин  
төгөлдөр болсон\*

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий Бага хурал,  
1948 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Сан Франциско хотноо гучин нэгдүгээр чуулганаа зарлан хуралдуулж,  
Чуулганы хэлэлцэх хэргийн төлөвлөгөөний 7-д тусгагдсан эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай тодорхой саналыг конвенцийн хэлбэрт оруулж батлахаар шийдвэрлэж,  
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн оршилд хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, энх тайван байдлыг хангах арга хэлбэр гэж “эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний зарчмыг хүлээн зөвшөөрөх явдал” хэмээн тунхагласныг анхаарч,  
Үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь хөгжил дэвшлийн зайлшгүй нөхцөл мөн гэж Филадельфийн тунхаглалд цохон тунхагласныг анхаарч,  
Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурал гучдугаар чуулганаасаа олон улсын зохицуулалтын үндэс болох зарчмуудыг санал нэгтэй батласныг анхаарч,  
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей хоёрдугаар чуулганаараа эдгээр зарчмыг нэгтгэн олон улсын нэг буюу хэд хэдэн Конвенц боловсруулахыг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хүссэнийг анхаарч,  
1948 оны 7 дугаар сарын 9-ний энэ өдөр Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай доорхи Конвенцийг батлав:

## I ХЭСЭГ

### ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

#### 1 дүгээр зүйл

Энэхүү Конвенцид оролцогч Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр дор дурдсан заалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

#### 2 дугаар зүйл

Ажилчид, ажил олгогчдын ямар ч ялгаагүйгээр, урьдчилан зөвшөөрөл авалгүй өөрийн саналаар байгууллага байгуулах, түүнчлэн тэдгээр байгууллагад гагцхүү дүрэмд нь захирагдах нөхцөлтэйгөөр элсэн орох эрхтэй.

#### 3 дугаар зүйл

1. Ажилчид, ажил олгогчдын байгууллага дүрэм, захиргааны дотоод журмаа боловсруулах, төлөөлөгчдөө чөлөөтэй сонгох, дотоод захиргаа байгуулах, үйл ажиллагаагаа зохион байгуулах, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй байх эрхтэй.

2. Төрийн байгууллага энэхүү эрхийг хязгаарлах буюу түүнийг хууль ёсоор хэрэгжүүлэхэд саад тавихаас түтгэлзэнэ.

#### 4 дүгээр зүйл

Ажилчид, ажил олгогчдын байгууллагыг захиргааны журмаар тараах буюу үйл ажиллагааг нь түр ч гэсэн хориглож үл болно.

#### 5 дугаар зүйл

Ажилчид, ажил олгогчдын байгууллага нь, эвсэл холбоо болон ийм төрийн бусад байгууллага байгуулах, тэдгээрт нэгдэх эрхтэй бөгөөд, эдгээр байгууллага, эвсэл буюу холбоо нь ажилчид, ажил олгогчдын олон улсын байгууллагад элсэх эрхтэй.

#### 6 дугаар зүйл

2, 3, 4 дүгээр зүйлийн заалтыг ажилчид, ажил олгогчдын байгууллагын эвсэл,

холбоодын хувьд хэрэглэнэ.

#### 7 дугаар зүйл

Ажилчид, ажил олгогчдын байгууллага, тэдгээрийн эвсэл, холбоо хуулийн этгээдийн эрх олж авах нь 2, 3, 4 дүгээр зүйлийн заалтыг хэрэглэхэд саад болохгүй.

#### 8 дугаар зүйл

1. Ажилчид, ажил олгогчид, тэдний холбогдох байгууллага бусад хүн буюу зохион байгуулалт бүхий хамт олны нэгэн адил энэхүү Конвенцоор тэдэнд олгосон эрх хэрэгжүүлэхдээ үндэсний хуулиа хүндэлнэ.
2. Үндэсний хууль нь энэхүү Конвенцид заасан баталгааг үл хөндөх бөгөөд тэдгээр баталгааг зөрчихгүйгээр хэрэглэгдэнэ.

#### 9 дүгээр зүйл

1. Энэхүү Конвенцоор заасан баталгааг зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын хувьд ямар хэмжээгээр хэрэглэж болохыг үндэсний хууль, тогтоомжоор тодорхойлно.
2. Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 19 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан зарчмын дагуу Байгууллагын аливаа гишүүн энэхүү Конвенцийг соёрхон батлах нь зэвсэгт хүчний болон цагдаагийн байгууллагад энэхүү Конвенцоор заасан баталгааг олгож буй хүчин төгөлдөр холбогдох хууль, шүүхийн байгууллагын шийдвэр, заншил буюу хэлэлцээрийг үл хөндөнө.

#### 10 дугаар зүйл

Энэхүү Конвенцид дурдсан “байгууллага” гэсэн нэр томъёонд нь ажилчид, ажил олгогчдын ашиг сонирхлыг хангах, хамгаалах зорилго бүхий ажилчид буюу ажил олгогчдын аль ч байгууллага хамаарна.

## II ХЭСЭГ

БАЙГУУЛЛАГА      БАЙГУУЛАХ      ЭРХИЙГ  
ХАМГААЛАХ

#### 11 дүгээр зүйл

Энэхүү Конвенц өөрийнх нь хувьд хүчин төгөлдөр болсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын аливаа гишүүнээс ажилчид, ажил олгогчдын байгууллага байгуулах эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай, зохих арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

### III ХЭСЭГ

#### БУСАД ЗААЛТ

##### 12 дугаар зүйл

1. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1946 оны шийдвэрийн дагуу өөрчилсөн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 35 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт дурдсан нутаг дэвсгэрээс бусад тэрхүү зүйлд дурдсан нутаг дэвсгэрийн хувьд, энэхүү конвенцийг соёрхон батласан гишүүн түүний соёрхон баталсны дараа аль болох богино хугацаанд дор дурдсан мэдэгдлийг Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд илгээнэ:

(a) Конвенцийн заалтыг өөрчлөлтгүйгээр хэрэглэх үүрэг авч байгаа газар нутаг дэвсгэрийн тухай;

(b) Конвенцийн заалтыг ямар нэг өөрчлөлттэй хэрэглэх үүрэг авч байгаа нутаг дэвсгэр болон тэдгээр өөрчлөлтийн тухай нарийвчилсан мэдээ;

(c) Конвенцийг хэрэглэхгүй нутаг дэвсгэр болон энэ тохиолдолд түүнийг хэрэглэж болохгүйн шалтгааны тухай;

(d) Шийдвэр хэрхэн гаргахаа азнаж буй нутаг дэвсгэрийн тухай;

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b) дэд хэсэгт дурдсан үүргүүд нь соёрхон батласан баримт бичгийн салшгүй хэсэг бөгөөд түүнтэй адил хүчинтэй байна.

3. Байгууллагын аль ч гишүүн шинэ мэдэгдэл хийж, энэ зүйлийн 1 дэх хэсгийн (b), (c), (d) дэд хэсэгт дурдсаны дагуу урьд өмнө хийсэн тайлбараасаа бүхэлд нь буюу хэсэгчилэн татгалзаж болно.



4. Байгууллагын аль ч гишүүн энэхүү конвенцийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг цуцалж болох хугацаанд урьдах аливаа мэдэгдлийнхээ нөхцлийг өөрчилж, тодорхой нутаг дэвсгэрт үйлчлэх нөхцлийн талаар шинэ мэдэгдлийг Ерөнхий захиралд илгээж болно.

#### 13 дугаар зүйл

1. Бүрэлдэхүүнд нь багтдаг боловч энэхүү Конвенцид холбогдох асуудлууд өөрийн нь шууд эрх мэдэлд багтах нутаг дэвсгэрийн засаг захиргаатай тохиролцсоны үндсэн дээр түүний гадаад харилцааг нь хариуцдаг тус байгууллагын гишүүн тухайн нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү Конвенцийн дагуу үүрэг хүлээхээ Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд мэдэгдэж болно.

2. Энэхүү конвенцийн дагуу үүрэг хүлээж буй тухайгаа Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд мэдэгдэж болно.

(а) Байгууллагын хоёр буюу хэд хэдэн гишүүнээс тэдний хамтын удирдлагад байгаа нутаг дэвсгэрийн хувьд;

(b) Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм буюу тухайн нутаг дэвсгэрт холбогдох ямар нэгэн хүчин төгөлдөр тогтоолын үндсэн дээр тэр нутаг дэвсгэрийг удирдах үүрэг бүхийн олон улсын аливаа засаг захиргаа.

3. Энэ зүйлийн өмнөх заалтад дурдсаны дагуу Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд илгээх мэдэгдэлд тухайн нутаг дэвсгэрт Конвенцийн заалтыг өөрчлөлттэй буюу өөрчлөлтгүй хэрэглэхийг заах бөгөөд Конвенцийн заалтыг өөрчлөлттэй хэрэглэх тухай мэдэгдэлд заасан бол уг өөрчлөлтийн тухай түүнд тодорхой дурдана.

4. Байгууллагын холбогдох гишүүн, гишүүд буюу олон улсын засаг захиргаа нь шинэ мэдэгдэл гаргаж, урьд өмнө хийсэн аливаа мэдэгдлийнхээ тайлбараас бүрэн буюу зарим хэсгээс нь татгалзаж болно.

5. Байгууллагын холбогдох гишүүн, гишүүд буюу олон улсын засаг захиргаа нь

Конвенцийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг цуцалж болох хугацаанд урьдах аливаа мэдэгдлийнхээ нөхцлийг өөрчилсөн тухай болон энэхүү Конвенцийг хэрэглэж байгаа байдлын тухай шинэ мэдэгдлийг Ерөнхий захиралд илгээж болно.

#### IV ХЭСЭГ

##### ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

###### 14 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийг албан ёсоор соёрхон батласан тухайгаа Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд бүртгүүлэхээр илгээнэ.

###### 15 дугаар зүйл

1. Энэхүү Конвенц нь соёрхон батласан тухайгаа Ерөнхий захиралд бүртгүүлсэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүдийн хувьд хүчинтэй байна.
2. Энэхүү Конвенц нь Ерөнхий захирал Байгууллагын хоёр гишүүн соёрхон батласан батламж жуух бичгийг бүртгэснээс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.
3. Үүний дараа энэхүү Конвенц нь Байгууллагын гишүүн бүрийн хувьд тийнхүү соёрхон батласанаа бүртгүүлснээс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

###### 16 дугаар зүйл

1. Энэхүү Конвенцийг соёрхон батласан гишүүн түүнийг анх хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жилийн дараа цуцлах тухай хүсэлтээ Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд мэдэгдэж бүртгүүлэх замаар Конвенцийг цуцалж болно. Цуцлалт нь бүртгэснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү Конвенцийг соёрхон батласан аль ч гишүүн өмнөх заалтад дурдсан арван жилийн хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор энэ зүйлд заасан цуцлах эрхийг

эдлээгүй бол, дараагийн арван жилийн хугацаанд уг Конвенцийг дагаж мөрдөх буюу цаашид түүнийг энэ зүйлд тогтоосон журмаар арван жилийн хугацаа дууссан тухай бүр цуцалж болно.

#### 17 дугаар зүйл

1. Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал Байгууллагын гишүүдийн соёрхон батласан тухай болон, мэдэгдэл, цуцлалтыг хүлээн авч бүртгэснээ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бүх гишүүнд уламжилна.

2. Ерөнхий захирал соёрхон батласан тухай хоёр дахь баримт бичгийг хүлээн авч бүртгэснээ Байгууллагын гишүүдэд мэдэгдэхдээ энэхүү Конвенц хүчин төгөлдөр болох он, сар, өдрийг сануулна.

#### 18 дугаар зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал өмнөх зүйлүүдэд заасны дагуу соёрхон батласан, мэдэгдэл, цуцалтыг бүртгэсэн бүрэн мэдээг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлэхээр илгээнэ.

#### 19 дүгээр зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай гэж үзэх бүртээ энэхүү Конвенцийг хэрхэн хэрэглэж байгаа тухай Ерөнхий Бага хуралд тайлагнах бөгөөд түүнийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хянан үзэх тухай асуудлыг Бага хурлын хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

#### 20 дугаар зүйл

1. Хэрэв энэхүү Конвенцийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хянан үзсэн шинэ Конвенцийг Бага хурлаар баталж, тэрхүү Конвенцид өөрөөр заагаагүй бол:

(а) Хянан өөрчилсөн шинэ Конвенц хүчин төгөлдөр болсон нөхцөлд Байгууллагын аль



нэгэн гишүүн түүнийг баталмагц тухайн гишүүний хувьд энэхүү Конвенц 16 дугаар зүйлийн заалтыг харгалзахгүйгээр нэн даруй хүчингүй болно.

(b) Хянан өөрчилсөн шинэ Конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн энэхүү Конвенцийг Байгууллагын гишүүд соёрхон батлах явдал дуусгавар болно.

2. Энэхүү Конвенц нь түүнийг соёрхон батласан бөгөөд хянан өөрчилсөн шинэ Конвенцийг соёрхон батлаагүй гишүүдийн хувьд ямар ч тохиолдолд хэлбэр, агуулгаараа хүчин төгөлдөр хэвээр байна.

#### 21 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийн англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.